

## **ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР ЗӨВЛӨМЖ**

2022 он 01 сар 08 өдөр

Арвайхээр

### **Бат-Өлзий сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний тухай**

#### **Нэг. Зорилго**

Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрээр өгөгдсөн үүрэг, даалгаврын биелэлт, байгууллагын чиг үүргийн болон нээлттэй байдлын үзүүлэлтэд хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх, гарсан дүгнэлт зөвлөмжийг дараагийн шийдвэр, бодлого төлөвлөлтөд тусгах, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

#### **Хоёр. Үндэслэл, арга зүй**

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, аймгийн Засаг даргын 2021 оны А/342 дугаар захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

#### **Гурав: Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ**

##### **Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт:**

-Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хяналтад авах үйл явцын хувьд аймгийн Засаг даргын 2015 оны а/149 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангаж, бүртгэл хяналтын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Харин шийдвэрийн цахим мэдээллийн сан бүрдүүлэлт хангалтгүй байна гэж үзлээ. Цахим мэдээллийн санг холбогдох шийдвэрийг он оноор нь хяналтад авагдсан байдал, хяналтаас хасагдсан байдал, тухайн шийдвэрийн хэрэгжилт тогтмолжсон эсэх, хүчингүй болсон эсэх гэх мэтээр шийдвэрүүдээ хянахад чиглэгдэнэ. Ийм цахим санг байгууллагын (Тамгын газар болон төсөвт байгууллагууд) хэмжээнд хийх шаардлагатай.

-Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн бүртгэлийн дэвтэр, тайлагналт зөрүүтэй байна. (Тайланд нийт 2021 оны байдлаар шинээр бүртгэсэн 12 шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнасан бол бүртгэлийн дэвтэрт 8 шийдвэр бүртгэлтэй байна. Эрүүл мэндийн салбарын хүрээнд гарсан шийдвэрийн бүртгэл хяналт 2018-2021 оны хооронд шинээр бүртгэл хяналтад авч, тайлагнагдсан шийдвэр байхгүй байна гэх мэт дутагдалтай.)

-Төсөвт байгууллагуудын хувьд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн бүртгэл хяналт хангалтгүй байна. Цаашид салбарын үйл ажиллагаатай холбоотой болон нийтлэг мөрдөгдөх шийдвэрийн бүртгэл хяналтыг сайжруулах, хэрэгжилтийг тооцож ажиллахад анхаарах

-Хуулиудыг хяналтад авах, бүртгэлжүүлэх, хэрэгжилтийг тооцох асуудалд анхаарах. Энэ чиглэлээр бусад байгууллага, албан хаагчдыг арга зүйгээр хангаж ажиллах.

-Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайлагналт хэт нуршуу, задгай бичигдсэн байна. Цаашид тайлагналтыг үр дүн, үр нөлөөнд тулгуурлаж бичих чадварт бүх албан хаагчдыг сургах, чадавхжуулах

#### **Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр:**

- 14 зорилтын 23 заалтыг хяналтад авч, хэрэгжилтийг тооцсон. Хяналтад авагдсан зорилт арга хэмжээ дутагдалтай байна. Тухайлбал нийтийн биеийн тамир (2.2), боловсрол (2.3), Хөдөлмөр нийгмийн хамгаалал (2.5), Аялал жуулчлал (3.4), Амар тайван аюулгүй байдал (4.3), Ногоон хөгжил (5.1), Ногоон хөгжил (5.1) зэрэг зорилтуудаас хяналтад огт авагдаагүй байна.

- Тайлангийн чанарт анхаарах шаардлагатай. Үйл ажиллагааны үр дүн жил бүр өссөн дүнгээр тооцогдоно. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын 6 дугаар зүйлийн 6.8-т зорилт, арга хэмжээ, заалтын гүйцэтгэл, үр дүнг 2000 тэмдэгтэд багтаана гэж заасан бөгөөд уг заалтын хэрэгжилтийг хангахад анхаарах

#### **Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт:**

- Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнахдаа Монгол улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, аймгийн Засаг даргын 2021 оны А/342 дугаар захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу зорилт, арга хэмжээний томъёололтой уялдуулж, товч тодорхой, тоон үзүүлэлтээр илэрхийлэх

- Үйл ажиллагааны хэрэгжилтийг процессыг нэг бүрчлэн нуршиж бичих биш, гарсан үр дүнг, тоогоор илэрхийлэх боломжтой арга хэмжээг суурь түвшин, зорилтот түвшинтэй харьцуулж бодитой тайлагнах.

- Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн зарим тоон үзүүлэлт баримтаар нотлогдохгүй байгаа нь тайлагналт бодитой биш байгаа нь харагдаж байна. Тухайлбал: Шинэ ажлын байр 116, түр /улирлын/ 100, зуучлал 41 –ээр нэмэгдүүлсэн.

#### **Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт:**

- Ажлын байрны зураг авалт хийх, ажлын ачааллыг сайтар тооцож, зэргээр ажил үүргийн хуваарийн хийдэл, давхардлыг арилгах, ажил хариуцсан мэргэжилтнүүдийг тухайн салбарын хөгжлийн чиг хандлагыг судалж, ажлын хариуцлагыг сайжруулах, өөрийгөө хөгжүүлэх боломжийг бүрдүүлэхэд анхаарах.

- Сумын жилийн хөгжлийн төлөвлөгөө, Орон нутгийн төсөв, ОНХС-ын хөрөнгөөр аль болох цөөн тооны хэрэгжих боломжтой төсөл, арга хэмжээг төлөвлөх.

- Биелэлтийн хувийг гаргахдаа журам, аргачлалд нийцүүлж, бодитой тооцох, тухайлбал, тухайн төсөл, арга хэмжээнд шаардагдах төсөв хөрөнгийг дараа онд батлуулахаар төлөвлөж байна гэж тайлагнаад биелэлтийг 50%-тай.

#### **Дөрөв: Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ**

#### **Аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт:**

- Гэрээний үүргийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, гэрээний шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг тоон болон чанарын шалгуурыг хэрхэн хангасан тухай үр дүнд тулгуурлан тайлагнах

- Зорилтот жилийн хэрэгжилтийг сумын ИТХ-аас 90.2 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн, Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлт дээр зорилтот жилийн хэрэгжилтийн үнэлгээг 100 хувийн биелэлт гаргасан.

- Ажлын байрны зураг авалт хийх, ажлын ачааллыг сайтар тооцож, зэргээр ажил үүргийн хуваарийн хийдэл, давхардлыг арилгах, ажил хариуцсан мэргэжилтнүүдийг тухайн салбарын хөгжлийн чиг хандлагыг судалж, ажлын хариуцлагыг сайжруулах, өөрийгөө хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлэх

### **Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт**

Аймгийн Засаг даргын 2021 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн А/342 дугаар захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ, үнэлгээ хийх журам”-ын 4 дүгээр хавсралтын дагуу Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжүүлэх төлөвлөгөө байхгүй биелэлтийг гарган ажилласан байна. Аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 12-ны А/561 тоот захирамжаар батлагдсан хөтөлбөрийн дагуу төлөвлөгөө боловсруулан ажилласан байна. Цаашид төлөвлөгөөний хугацаа болон шалгуур үзүүлэлтийг бодитой тодорхойлж биелэлтийг оновчтой тайлагнах

### **Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт:**

“Бодлогын баримт бичиг болон хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ”-г хэрэгжүүлэх зорилгоор тухайн албан хаагч гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээг тодорхойлохдоо дараах арга зүйг мөрдлөг болгоно. Үүнд:

- Албан тушаалын зорилго, зорилтод үндэслэн албан хаагчийн гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээг томъёолох;

- Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, стратеги төлөвлөгөөнд тусгагдсан ижил нэршилтэй, ижил утгатай, бие биеэ агуулсан утгатай зорилт, арга хэмжээг нэгтгэж, нэг арга хэмжээ болгон тодорхойлох;

- Гүйцэтгэлийн зорилт болон зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ хоорондын уялдааг хангах;

- Байгууллагын гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээг бусад нэгж, эсхүл өөрийн нэгжийн албан хаагчтай хамтран хэрэгжүүлэхгүй тохиолдолд тухайн албан хаагч уг арга хэмжээ, түүний шалгуур үзүүлэлтийг өөрчлөхгүйгээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах;

- Байгууллагын гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээг бусад нэгж, эсхүл өөрийн нэгжийн албан хаагчтай хамтран хэрэгжүүлэх болсон тохиолдолд тухайн албан хаагч арга хэмжээ, түүний шалгуур үзүүлэлтийг дангаараа хэрэгжүүлж болохуйц байдлаар нарийвчлан тодорхойлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах;

- Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг тодорхой, хэмжигдэхүйц, хэрэгжихүйц, ач холбогдолтой, цаг хугацаатай байхаар тодорхойлох;

- Арга хэмжээний гол үр дүнг харуулсан 1-2 шалгуур үзүүлэлт сонгох, шаардлагатай тохиолдолд чанарын шалгуур үзүүлэлт ашиглах боломжтой ч аль болох үр дүнд суурилсан шалгуур үзүүлэлт сонгох;

-Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хугацааг жилээр бус улирлаар төлөвлөсөн байх.

-Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд (тамгын газрын) бодлого зохицуулалтын хүрээний гол гол арга хэмжээний төлөвлөлтүүдийг хийдэг байх (сумын жилийн хөгжлийн төлөвлөгөө болон албан хаагч тус бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нарийвчилсан арга хэмжээнүүд орж байгаа учраас үйл ажиллагаа нэг бүрийг тусгах шаардлагагүй)

-Албан хаагчийн болон байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд төсөв тавигдсан арга хэмжээнүүд байгаа бөгөөд гүйцэтгэл үр дүнд тухайн төсвийн гүйцэтгэлийг тусгаагүй алдаатай байна.

-Төсөвт байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөний боловсруулалт, төлөвлөлтөд хяналт тавих. Арга хэмжээг оновчгүй тодорхойлсон, шалгуур үзүүлэлтийг хэмжигдэхүйц байх шаардлагыг хангаагүй, суурь түвшин тавигдаагүй, зорилтот түвшинг ойлгомжгүй тодорхойлсон, үнэлгээг буруу томъёолсон, үнэлгээний хүснэгтийг буруу ашигласан зэрэг дутагдлыг дахин гаргахгүй байх.

-Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хувьд стратегийн төлөвлөгөөний зорилго, зорилт, арга хэмжээ гэж задарч томъёологдсон байгааг анхаарах.

**Орон нутгийн хөгжлийн сан, хөрөнгө оруулалтын талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн хувь, хувийн хэвшлийг дэмжсэн байдал:**

2021 онд тус сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний 8 төсөл, арга хэмжээ нийт 469,307,700 төгрөгөөр батландсан байна. Батлагдсан 8 төсөл арга хэмжээний 7 төсөл арга хэмжээ бүрэн санхүүжигдэж 1 төсөл, арга хэмжээ он дамжин санхүүжигдэхээр болсон байна. 2021 онд хийгдсэн жилийн гүйцэтгэлийн үнэлгээгээр 94 хувиар 7 дугаар байранд орсон байна.

Сум хөгжүүлэх сангийн зээлийг 2021 онд шинээр 12 иргэнд 49,000,000 сая төгрөгийн зээлийг олгож 2021 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар 56 иргэнээс 158,400,000 сая төгрөгийн авлагатай гарсан байна. Нийт 24 иргэнд 61,009,728 сая төгрөгийн акт тавигдсанаас 22 иргэний 58,704,106 сая төгрөг төлөгдөж актын биелэлт 96 хувьтай, албан шаардлагыг 22 иргэнд хүргүүлж ажилласнаар албан шаардлагын биелэлт 72 хувьтай байна. Цаашид гэрээний хугацаа дууссан 10 иргэн, явцын хугацаа хэтрэлттэй 6 иргэний нийт 36,000,000 сая төгрөгийн үндсэн зээл болон зээлийн хүүгийн авлагад анхааран ажиллах.

#### **Тав: Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ**

##### **Байгууллагын ил тод байдлын үнэлгээ:**

Аймгийн Засаг даргын 2021 оны А/342 дугаар захирамжаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын 10 дугаар хавсралтад туссан “Байгууллагын ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-ийг Үйл ажиллагааны ил тод байдал, Хүний нөөцийн ил тод байдал гэсэн 2 ангиллын 14 шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэв.

Тус сумын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн жилийн эцсийн хэрэгжилтийн тайланд үндэслэж, бодит нөхцөл байдлыг газар дээр нь судалж, вэб сайт, мэдээллийн самбарын хөтлөлт, баяжилтыг харгалзан үзсэн.

Албан ёсны вэб сайтын хөгжүүлэлт тогтмолжсон. Мэдээллийн самбарыг электрон болон цаасан хэлбэрээр хэрэглэж, үйл ажиллагааг жигдрүүлсэн. Ил тод байдлыг хангах төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг тооцон ажилласан байна.

Цаашид ил тод байдлыг хангаж ажиллахад дараах зүйлсийг анхаарах

- Сумын бодлогын баримт бичгүүдийг вэб сайтад нийтлэх
- Төрийн байгууллагуудад ажиллаж буй нээлттэй утасны дугаарыг нэгтгэж ил тод мэдээлэх
  - Өргөдөл, гомдлыг цахимаар хүлээж авах өгөгдлийг вэб сайтад бий болгох
  - Олон нийтээс санал асуулга авах өгөгдлийг вэб сайтад бүрдүүлэх
  - Сул орон тооны зарыг тогтмол мэдээлэх
  - Сумын эдийн засаг нийгмийн өнөөгийн байдал, төрийн албан хаагчдын утасны дугаарыг тухай бүр шинэчлэх
    - Төсөвт байгууллага тус бүрд ил тод байдлыг хангах цэс нээж өгөх
    - Өргөдөл гомдлын мэдээллийн шийдвэрлэлт, холбогдох журмыг мэдээлэх
    - Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн утасны дугаарыг нийтлэх
      - Сошиал сүлжээнд төрийн байгууллага бүр өөрийн албан ёсны хаягаас мэдээлэл нийтлэх /Албан хаагчид хувийн хаягнаас төрийн мэдээлэл нийтлэхгүй байх/
      - <http://bat-ulzii.ov.gov.mn/> вэб сайтыг олон нийтэд сурталчлах
      - Сум, орон нутгийн бодлого шийдвэр, түүний хэрэгжилтийн явц, үр дүнг сонин, сэтгүүл, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэх
      - Сумын цаг үеийн ажлыг вэб сайтад нийтлэх

### **Шударга байдлын түвшний үнэлгээ:**

“Сумын авлига, ашиг сонирхлын зөрчлийн эсрэг 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө” “Сум, байгууллагын авлигийн эсрэг үйл ажиллагаа, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн зорилт арга хэмжээг хэрэгжүүлэх 2021 оны төлөвлөө”-ний жилийн эцсийн биелэлтийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсээс үнэлсэн шударга байдлын үнэлгээтэй харгалзан газар дээр нь ажиллаж дүгнэв.

- Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр өөрсдийн нөөц бололцоог ашиглаж шторк, видео бэлтгэж сумын албан ёсны вэб сайтад тусгай цэс үүсгэн тогтмол байрлуулах. Нөлөөллийн ажлуудыг санаачлан зохион байгуулж, иргэдийг олноор хамруулах
  - Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг иргэдээс авч хэвших
  - Худалдан авах ажиллагааны цэсийг ажиллагаанд оруулах, жилийн төлөвлөгөө, тайлан, аудитын тайлан, тендерийн урилгыг нийтэлж, холбогдох линкийг холбох

### **Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээ:**

Шилэн дансны сайтад 2021 оны 3 дугаар улирлын байдлаар сумын Засаг даргын Тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, ерөнхий боловсролын сургууль эдгээр байгууллага хугацаа хоцорч оруулсан мэдээлэл байхгүй, хуулийн хугацаандаа мэдээллээ байршуулж хэвшсэн байна. Ерөнхий боловсролын сургууль хугацаа хоцорсон мэдээлэл- 1, 1 дүгээр цэцэрлэг хугацаа хоцорсон мэдээлэл-20, 2 дугаар цэцэрлэг хугацаа хоцорсон мэдээлэл-4, эмнэлэг хугацаа хоцорсон мэдээлэл -4, соёлын төв хугацаа хоцорч 4 мэдээлэл оруулсан байна.

### **2020 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилт**

- Зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө боловсруулан ажилласан. Төлөвлөгөөний хэрэгжилтийг тооцож ажилласан сайн талтай.

- Байгууллагын ёс зүйн зөвлөл болон дотоод хяналтын зөвлөлийн үйл ажиллагаа тогтмолжсон. Цаашид үйл ажиллагааны үр дүнг сайжруулахад анхаарах
- Төрийн албан хаагч бүр хариуцсан ажлын хүрээнд судалгаа, мэдээллийн сантай байх,
- Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 246 дугаар тогтоолоор батлагдсан Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн С/30 дугаар тушаалаар батлагдсан Баримт бичиг стандарт (MNS 5140:2021)-ын хэрэгжилтийг хангаж ажиллах. Тухайлбал: Хуралдааны тэмдэглэл, зөвлөмж, илтгэх хуудас зэргийг стандартын шаардлагад нийцүүлэх

**Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газар, Төрийн албаны салбар зөвлөлөөс өгсөн хугацаатай үүрэг даалгавар, мэдээ тайлангийн ирц, чанарын үнэлгээ:**

Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газар, Төрийн албаны салбар зөвлөлөөс өгсөн хугацаатай үүрэг даалгавар, мэдээ тайлангийн ирц, чанарын үнэлгээг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс гаргаж өгсөн үнэлгээтэй харгалзаж газар дээр нь ажиллаж, холбогдох бичиг баримтыг үзэж үнэлэв.

Тус сумын Засаг даргын Тамгын газарт 2021 онд хугацаатай бичиг 63 ирснийг хяналтын карт нээгээгүй, бүртгэлийн дэвтэр дээр хариу өгөх хугацааг тэмдэглээгүй, шийдвэрлэлтийн байдал дээр тайлбарыг буруу бичсэн. Төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд ирүүлсэн өргөдөл 488 ирснийг хяналтын карт нээгээгүй, бүртгээгүй зэрэг алдаа дутагдлыг даруй засаж сайжруулах шаардлагатай.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ХЭСЭГ